



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Сургалтын жишиг хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Г.Батдорж/-т даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/-т үүрэг болгосугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/151 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201386

ХҮҮХЭД ХАРАГЧИЙГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийтлэг үндэслэл: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, “Бага насны хүүхдийн хөгжил MNS-5420-1:2011 стандарт, Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015” стандарт зэрэг эрх зүйн баримтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллага хүрэлцээгүйн улмаас цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, ажилгүй иргэд ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эцэг эх, асран хамгаалагчийн ажил хөдөлмөрөө эрхлэх боломжийг олгох төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг 2015 онд баталсан.

Энэхүү хууль болон Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6540:2015 стандартын шаардлагад нийцсэн бага насны хүүхэдтэй ажиллах зөв мэдлэг, ур чадвар, эв дүй, эерэг хандлагатай хүүхэд харагчийг бэлтгэх жишиг сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

Хамрах хүрээ:

Аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтэст Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтад хамрагдахаар хүсэлт гаргасан бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой 18-60 насны Монгол Улсын иргэн.

Сургалтын арга зүй:

Сургалтыг зохион байгуулахдаа онол болон дадлага ажлыг хослон хэрэглэж, суралцагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан явуулна.

Оролцогчдод тавигдах шаардлага

Багшид тавигдах шаардлага	Суралцагчдад тавигдах шаардлага
Сургалтыг багаар зохион байгуулах бөгөөд багийн гишүүд нь: - Хүүхдийн эрх хамгаалал, хүүхдийн хоол тэжээл, хүүхдийн эрүүл ахуй, СӨБ-ын сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлал, сургалтын арга зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн, 3-аас дээш жил ажилласан туршлагатай байх. - Сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг хөтөлбөрийн дагуу боловсруулан бэлтгэл хангаж, сургалтыг чанартай зохион байгуулах заах арга, ур чадвартай байна.	-Хүүхдийн эрхийн зөрчил гаргаж байгаагүй; Хүүхэдтэй ажиллах сонирхолтой, хүүхэд хамгааллын бодлоготой танилцсан; -Хүүхэд харах үйлчилгээ эрхлэн ажиллах хүсэлтэй. - Сургалтад өөрийн биеэр бүрэн хамрагдах боломжтой; - Сургалтын төлбөрөө төлсөн байх.

Сургалтад баримтлах зарчим:

1. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд зайлшгүй шаардлагатай бага насны хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт тохирсон хэрэгцээг дэмжин ажиллах ур чадвар, хүүхэд хамгаалах, хөгжүүлэх чадвартай ажилтныг бэлтгэхэд чиглэсэн агуулгыг практик үйл ажиллагаагаар дамжуулан эзэмших нөхцөлийг бүрдүүлэх
2. Сургалтын арга зүй нь суралцагчийн оролцоог дэмжсэн, хамтран суралцах бүтээлч байдлыг дэмжсэн байна.

ХОЁР. СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- Хүүхэд харагч бэлтгэх сургалтын зорилго нь бага насны хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлог, хүүхдийн эрх, хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргад суралцаж, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн талаар ойлголт, мэдлэгтэй, хүүхэдтэй ажиллах эв дүй, зөв хандлагатай мэргэшсэн ажилтныг бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн хүрээнд суралцагчид нь дараах ур чадварыг эзэмшсэн байна. Үүнд:

- Бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар мэдлэг эзэмших;
- Бага насны хүүхдийн эрхийг дээдлэн асран хамгаалах, халамжлах үйл ажиллагааг эрхзүйн зохицуулалтын дагуу бүтээлчээр хэрэгжүүлэх чадвартай байх;
- Хүүхэд бүрийг эрүүл мэнд ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болоход дэмжлэг үзүүлэх;
- Хүүхдийг ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, хамгаалах;
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таньж мэдэх, илрүүлэх мэдлэг чадвартай байх;
- Бага насны хүүхдийн өсөлт хөгжилт, бие махбодод хэрэгцээт амин дэм, эрдэс бодисоор баялаг, илчлэг шим тэжээлтэй эрүүл хүнсийг технологийн дагуу бэлтгэн зөв хооллох мэдлэгтэй байх;
- Бага насны хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтийг байнга ажиглан, шаардлагатай дэмжлэг үзүүлэх, яаралтай үед эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх;
- Бага насны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай хүүхдийн хөгжлийн асуудлаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах чадвартай байх;
- Бага насны хүүхэдтэй харилцах харилцааны эв дүйтэй байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн хэлбэр, хэрэгцээнд тохируулан асрах, дэмжих үйлчилгээ үзүүлэх;
- Хүүхдэд ээлтэй, тэдний хөгжлийг дэмжсэн таатай орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах чадвартай байх;
- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжин ажиллах чадварт суралцана.

ГУРАВ. ХҮҮХЭД ХАРАГЧИЙН БЭЛТГЭХ СУРГАЛТЫН АГУУЛГА

Агуулгын багтаамж: Нийт 40 цаг 5 өдөр

- Суралцагчдын эзэмших, мэдлэг, ур чадвар, хандлага
- Сургалтаар хүүхэд харагчийн эзэмших чадамж

Д/д	Хүүхдийн эрх, хамгаалал	Хүүхдийн эрүүл ахуй, ариун цэвэр	Хүүхдийн хоол тэжээл	Хөгжлийг дэмжих арга зүй
Товч агуулга	-Хүүхдийн эрхийг хангах, -Асрах, халамжлах, хамгаалах үйл ажиллагаан даа эерэг хандлагатай байх	-Хүүхдэд ариун цэвэр, эрүүл ахуйн дадал, хэвшил олгох -Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдвар-гүйтлийг горимын дагуу чанартай хийх, -Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх -Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх	-Хүүхдийн хоол, жор, номыг тохируулах, -Хүнсний аюулгүй байдал, хадгалалтын горимыг баримтлах, -Хүүхдийн хордлого, өвчлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	-Бие бялдар, оюун ухаан, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, нийгэмшлийн хөгжлийг дэмжих зохион байгуулж хамтран ажиллах
Ерөнхий чадвар	Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын тухай үндсэн ойлголт, Хүүхэд харах үйлчилгээтэй холбоотой хууль, дүрэм, журам	Хүүхдийн байгууллагын ариун цэвэр, эрүүл ахуйн дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар	Эрүүл мэндийн сайдын баталсан 1-3, 4-6 насны хүүхдийн хоолны норм, хүнсний бүтээгдэхүүний жагсаалт	Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт, Хүүхдийн цогц хөгжлийн тухай ойлголт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй
Тусгай чадвар	-Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогийг мэдэх, эерэг харилцааны аргыг эзэмших -Хувь хүний зан төрх, хандлага эерэг, сонор сэрэмжтэй байх	-Гарын ариун цэвэр, амны хөндийн ариун цэвэр сахих, арчлах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх аргаас суралцах -Цэвэрлэгээний горим, технологийг мөрдөх	-Хүүхдийн хоол, тэжээлийг бэлтгэх, норм, нормативыг баримтлах, жор /меню/ зохиох, мөрдөх, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлын шаардлагыг хангах	-Үйл ажиллагааг төлөвлөх -Өдрийн дэглэм мөрдөх -тоглоом дасгал, хөдөлгөөн, дуу хөгжим -Дүрслэхүйн үйл ажиллагааг чиглүүлэх, -Хэрэглэгдэхүүн бэлтгэх

Чадамж-1 Хүүхдийн эрх, хамгаалал /Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд харах үйлчилгээний хууль, бусад холбогдох эрх зүйн зохицуулалт бүхий дүрэм, журам зааврыг танилцуулах, ажлын байранд хэрэгжүүлэх, хүмүүжлийн эерэг аргын тухай мэдлэг, хандлагыг эзэмших.

Чадамж-2 Бага насны хүүхдийн эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуй. /Гадаад ба дотоод орчны аюулгүй байдал, тоглоом наадгай, тавилга хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангах, хүүхдэд эрүүл аж төрөх ёсны анхны ойлголт өгөх, эрүүл ахуйн дадал хэвшилд сургах, орчны цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгалын стандартыг мөрдөх

Чадамж-3 Балчир болон бага насны хүүхдийн хоол тэжээл /Хүүхдийн хоол тэжээлийн онцлог, хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, жор, орц, норм, илчлэгийг зохицуулах

Чадамж-4 Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй /Өдрийн дэглэм мөрдөх, тоглоом, бусад хэрэглэгдэхүүн ашиглан бүтээлч сэтгэлгээ, эерэг харилцааг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

ДӨРӨВ. СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН АГУУЛГА

Лекц:16 цаг, Семинар, дадлага:8 цаг

Чиглэл	Хичээлийн сэдэв	цаг	Ашиглах материалын багц
Бага насны хүүхдийн эрх, хамгаалал	<p>1. Бага насны хүүхдийн эрхийг хамгаалах талаар шинээр гарсан хууль тогтоомж</p> <p>2. Хүүхэд харагчийн зүгээс бага насны хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх хууль зүйн үүрэг</p> <p>3. Бага насны хүүхдийг хүмүүжүүлэх эерэг аргын хэрэглээ</p> <p>4. Хүүхэд харах үйлчилгээнд хэрэгжүүлэх “Хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагаа”</p>	4	<p>-Багш лекцийн агуулгаар PPT бэлтгэх .</p> <p>-Мэдлэг бататгах асуулт, ярилцлага;</p> <p>-Хүүхдийн эрхийн тухай хууль;</p> <p>-Хүүхэд хамгааллын тухай хууль;</p> <p>-Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, дүрэм, журам, стандарт;</p> <p>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,</p> <p>-Зөрчлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж;</p> <p>-НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц;</p> <p>-НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 13 дугаар ерөнхий зөвлөмж ;</p> <p>- Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015” стандарт;</p> <p>-“Хүүхэд, эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх” гарын авлага, УБ, ГБХЗХГ, 2015;</p> <p>Хүмүүжлийн эерэг аргууд Ж.Дюррант (2010).;</p> <p>-Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлогын баримт бичиг.</p>

<p style="text-align: center;">Бага насны хүүхдийн хамгааллын үйлчилгээ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хүүхэд хамгаалал, хүүхдийг үл хайхрах байдал 2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлийн түвшин, аюулгүй байдлыг үнэлэх 3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх 4. Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх 	<p style="text-align: center;">4</p> <p>Багш лекцийн агуулгаар PPT бэлтгэх . Өмнө судалсан агуулгыг сэргээх асуултууд. Т.Цэндсүрэн нар Хүүхэд хамгаалал, цэцэрлэгийн багш эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага (2017), Улаанбаатар С.Энхтуяа Хүүхэд хамгаалал (2009), Улаанбаатар О.Мягмар, М.Нямдорж (2000) Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил А.Батхишиг Хүүхэд хамгааллын үйлчилгээ (2009), Улаанбаатар Б.Туяа Клиник практикт хэрэглэх хэмжүүр, тестүүд, орчуулга (2017), Улаанбаатар Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Бага насны хүүхдийг хөгжүүлэх (2012) Улаанбаатар Т.Цэндсүрэн,(2007) Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил. Улаанбаатар</p>
<p style="text-align: center;">Бага насны хүүхдийн эрүүл мэнд-хоол тэжээлийг сайжруулах арга зүй</p>	<ol style="list-style-type: none"> 1.Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал эзэмшүүлэх 2.Хүүхдийн эрүүл мэнд, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын мэдлэгийг сайжруулах 3.2-5 насны хүүхдийн хоол боловсруулах онцлог, хоолны хэмжээ, дэглэм, хэрэглэх, хориглох хүнс 4.Хүүхдэд өгөх хоолны илчлэг, шимт бодисын хэмжээ, хоолны цэс, технологийн карт мөрдөж ажиллах, хоол тэжээлийн боловсрол олгох 	<p style="text-align: center;">4</p> <p>Багш лекцийн агуулгаар PPT бэлтгэх Өмнө судалсан агуулгыг сэргээх асуултууд. Эрүүл мэндийн довтолгоо. Сургагч багшийн гарын авлага, УБ 2014, 12-25, 96-109 Цэцэрлэгийн хүүхдийн зохистой хооллолтын зөвлөмж БСШУЯ, НҮБ-ын хүүхдийн сан, Эцэг эхэд боловсрол олгох сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ 2015, 90-91</p>
<p style="text-align: center;">Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй</p>	<ol style="list-style-type: none"> 1.Бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог 2.Хүүхэдтэй ажиллахдаа тэдгээрийн зан үйлийн хувийн онцлогийг харгалзаж ажиллах нь 	<p style="text-align: center;">4</p> <p>Багш лекцийн агуулгаар PPT бэлтгэх. Өмнө судалсан агуулгыг сэргээх асуултууд. Бага насны хүүхдийн хөгжил MNS-5420-1:2011 стандарт Ж. Батдэлгэр Бага насны хүүхдийн сэтгэл судлал (2011) 4,5 бүлэг, Улаанбаатар Ж. Батдэлгэр, В. Туяа нар Хүний хөгжлийн сэтгэл судлал(2016),1,2 бүлэг, Улаанбаатар Ж. Батдэлгэр, Ш. Оросоо (2010), Бага насны хүүхдийн бие бялдар- сэтгэцийн хөгжил, Улаанбаатар</p>

	<p>3.Бага насны хүүхдэд номыг хэрхэн уншиж өгөх арга зүй</p> <p>4.Тоглох явцад хүүхдийн хөгжлийг дэмжих нь</p>	<p>О.Мягмар Сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэцийн хөгжлийн асуудал, Улаанбаатар БСШУЯ, НҮБХС, Эцэг эхэд боловсрол олгох сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ 2015, 90-91 Д.Лонжид (2011) Хүүхдээ хүн болгох ухаан, Улаанбаатар Ж.Дюррант(2010). Хүмүүжлийн зэрэг аргууд. Хасан Аядынлы (2008) Хүүхдийн хүмүүжлийн талаар асуулт, хариулт. Улаанбаатар 3-6 хүртэлх насны хүүхдэд уншиж өгөх номын жагсаалт Ч.Бямбацэцэг, Ж. Батдэлгэр (2014) Хүүхдийн номын ертөнц, Улаанбаатар Ц.Наранцэцэг (2008) Сургуулийн өмнөх насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх аргазүй, Улаанбаатар Ц.Оюунгэрэл (2005) гурав хүртэлх насны хүүхдийн хэл ярианы хөгжилд үзүүлэх орчны нөлөөлөл БСШУЯ, НҮБХС, Эцэг эхэд боловсрол олгох сургагч багш нарт зориулсан гарын авлага, 2015, 106-110, Улаанбаатар Т.Гэрэлтуяа, Д. Наранцэцэг нар. (2016) Тоглонгоо суралцахуй, Улаанбаатар Нямсүрэн С., Монгол ардын уламжлалт тоглоом, УБ., 2013</p>
--	--	---

Сургалтын цаг төлөвлөлт

№	Өдөр	Чадамж	Хугацаа	Цаг/Онол/дадлага
1.	1 өдөр	Бага насны хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал	9.00-13.00 Цайны цаг 13.00-14.00 14.00-18.00	3/5
2.	2 өдөр	Бага насны хүүхдийн эрүүл мэнд ариун цэвэр, эрүүл ахуй	9.00-13.00 Цайны цаг 13.00-14.00 14.00-18.00	3/5
3.	3 өдөр	Бага насны хүүхдийн хоол тэжээл	9.00-13.00 Цайны цаг 13.00-14.00 14.00-18.00	3/5
4.	4 өдөр	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй	9.00-13.00 Цайны цаг 13.00-14.00 14.00-18.00	3/5
5.	5 өдөр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй	9.00-13.00 Цайны цаг 13.00-14.00	4/1/3

	Дадлага, бие даалт Онолын шалгалт Ур чадварын тэмцээн	14.00-18.00	
--	---	-------------	--

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтыг лекц, семинар, дадлага хэлбэрийг хослуулан суралцагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан онол дадлагыг 40:60 харьцаатай зохион байгуулна.

- Хичээлээр суралцагчдыг ганцаарчилсан болон багаар ажиллах, дадлага ажлаас суралцах зэрэг хэлбэрээр суралцахуйн үйл ажиллагаанд чиглүүлнэ.
- Лекцийн хичээлээр онолын мэдээлэл, семинарын хичээлээр онолыг практикт хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дасгал даалгавар, тохиолдлын жишээн дээр суралцаж, оролцогч өөрөө үйлийн эзэн байх, асуудлыг шийдвэрлэх арга барил ур ухаанд чиглэгдэнэ.
- Дадлага нь танилцах, практик ур чадвараас эзэмшихэд чиглэгдсэн үйл ажиллагаанд суурилсан байна.

Хичээлд хэрэглэх арга

Үйл ажиллагаа	Лекц	Семинар	Дадлага
Багшийн үйл ажиллагаа	-Мэдээлэл дамжуулах -цахим илтгэл хийх /PPT/ -Асуудал дэвшүүлэн тайлбарлах - Харилцан ярилцах	- Асуулт тавих - Асуудал дэвшүүлэх -Багийн ажил төлөвлөх -Хэлэлцүүлэг удирдах -Кейс бэлтгэх	-Удирдамж заавар өгөх -Дадлагын хуваарь хийх -Зөвлөн туслах -Ганцаарчлан ажиллах
Суралцагчийн үйл ажиллагаа	-мэдээлэл хүлээн авах -мэдээллийг боловсруулах -Харилцан ярилцах -Асуулт тавих -Асуултад хариулах	-оролцооны арга -Бүлгээр ажиллах -Кейстэй мэдээлэлтэй ажиллах -Эвлүүлэг, солилцоо хийх -Дүрд тоглох	-Дадлага ажлаа төлөвлөх -Биечлэн үзүүлэх -Дасгал хийх -Дадлага ажлаа эргэцүүлэн үнэлэх

Дадлага, лаборатори ажлын заавар удирдамж

№	Дасгал, дадлага ажил, түүний сэдэв	Ноогдох цаг	Цуглуулах оноо	Ашиглах материал
1	Дасгал	4	4 оноо	Гарын авлага, холбогдох материалыг ашиглах
2	Дадлага	4	4 оноо	Гарын авлага, холбогдох материалыг ашиглах
3	Дадлага	4	4 оноо	Холбогдох сургалтын материал, лекцийн материалыг ашиглах
4	Дасгал ажиллах	4	4 оноо	Сургалтын материал, лекцийн материалыг ашиглах

ЗУРГАА. СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Сургалтын орчин: Аймаг, Нийслэл, Дүүргийн “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс”-ийн сургалтын танхимд зохион байгуулна.
2. Сургалтын гарын авлага болон агуулга:
 - Хүүхдийн эрхийн тухай хууль
 - Хүүхэд хамгааллын тухай хууль
 - Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль
 - Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6540 : 2015
 - ХНХС-ын 2022 оны 02 сарын А/26 тоот тушаалаар батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах хяналт тавих тухай журам”
 - Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэдэд зохион байгуулах сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр
 - Балчир болон бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил, нийгэмшил
 - Хүүхдийн хөгжлийн үндсэн ай, нөлөөлөх хүчин зүйлс
 - Хүүхдийн хөгжлийн дэмжих арга зүй
 - Хүмүүжлийн эерэг арга түүнийг хэрэгжүүлэх нь
 - Хүүхдийн хоол тэжээл, бэлтгэх арга ажиллагаа
 - Цэцэрлэгийн хүүхдийг осол гэмтлээс хамгаалах дүрэм
 - Хүүхдийн өдрийн дэглэм
 - Хүүхдийн хөгжлийг өдөр тутмын үйл ажиллагаагаар дэмжих нь
 - Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийн ёс зүй, харилцаа, хандлага, арга барил
 - Бага насны хүүхдийн дуу, шүлэг, үлгэрийн эмхтгэл DVD, CD, бичлэгтэй хуурцаг

Сургалтын хэрэглэгдэхүүн

- LCD проектор, дэлгэц
- Самбар, самбарын үзэг
- Дэлгэц цаас, пламастер

Багшийн хэрэглэгдэхүүн

- Лекц PPT –цахим илтгэл
- Семинарын төлөвлөлт
- Дадлагын удирдамж
- Тараах материал

Суралцагчдын хэрэглэгдэхүүн

- Дэвтэр, үзэг, зургийн дэвтэр, харандаа, пламастер, өнгийн цаас, цавуу, хайч, баримлын шавар, баримлын шаврын суурь, усан будаг, бийр

ДОЛОО. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний шалгуур

- Ирц, идэвхи, оролцоо
- Мэдлэг, хандлага илрүүлэх сорил
- Дадлагын явц

1. Ирц, идэвх, оролцоо: Ирцийг хичээлд биеэр сууж оролцсон байдлыг бүртгэнэ. Оролцоог асуулт тавьсан, асуудал дэвшүүлсэн, багийн ажилд оролцсон, хичээлийг бичиж тэмдэглэсэн байдал, хичээл сургалтад хандах хандлага зэргийг харгалзан үнэлнэ.
2. Мэдлэг хандлага илрүүлэх сорил: Сургалтын агуулгын дагуу сорил даалгавар гүйцэтгэнэ. Сорил даалгавар боловсруулна. Сорилыг үнэлэх журам: 25 даалгавар тус бүр 4 сонгох хариулттай бөгөөд хариулт бүр 1-4 хүртэл оноотой. Дээд оноо 100, доод оноо 25 авна.
3. Дадлагын эргэцүүлэл: дадлагын бэлтгэл, явц, ажигласан болон олж мэдсэн зүйл, асуудал, түүнийг шийдвэрлэх боломж зэргийг эргэцүүлэх ярих буюу эргэцүүлэл бичвэр бичнэ.

Суралцагчийн үнэлгээ

- Суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээ нь үндэслэлтэй, бодитой, шударга ил тод зохион байгуулагдаж шалгалтын оноогоор үнэлнэ.
- Тухайн хичээлээр суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг ирц-20 оноо, явц-40 оноо, шалгалт-40 оноо буюу нийт 100 оноогоор дүгнэнэ.
- Суралцагч нийт 60-аас доош буюу хангалтгүй үнэлэгдсэн тохиолдолд уг хичээлийн агуулгыг дахин нөхөж судална.
- Суралцагч хоёр ба түүнээс дээш хичээлд хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд гэрчилгээг авч төгсөх боломжгүй болно.

---o00o---